

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/17/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг:
MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.00	0.00	0.00
Арилжааны банкны харилцах данс	3.4	0.8	-2.6
Төрийн сангийн харилцах данс	287.7	185.4	-102.3
Дүн	291.1	186.2	-104.9
Үүнээс: байгууллагаар харуулбал			
Орон нутгийн ерөнхий орлого	183.1	151.4	-31.7
Хоршоо хөгжүүлэх сан	37.7	29.5	-8.2
Орон нутгийн хөгжлийн сан	67.0	4.5	-62.5
Түнэл Илч ХХК	3.4	0.8	-2.6
Нийт дүн	291.1	186.2	-104.9

Эх сурвалж: Түнэл сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, Бууралт /-/
Хоршоо хөгжүүлэх сан	54.1	65.4	11.3
Орон нутгийн хөгжлийн сан	25.0	25.0	0.0
Түнэл Илч ХХК	1.7	1.7	-0.04
Нийт дүн	80.8	92.1	11.3

Эх сурвалж: Түнэл сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгт 3. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2.3	2.7	0.4
Засаг даргын Тамгын газар	99.9	115.0	15.1
Түнэл Илч ХХК	46.5	41.5	5.0
Нийт дүн	148.7	159.3	10.6

Эх сурвалж: Түнэл сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгт 4. Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хоршоо хөгжүүлэх сан /Хувь хүмүүст олгосон зээл/	95.9	92.7	-3.2
Дүн	95.9	92.7	-3.2

Эх сурвалж: Түнэл сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-
Засаг даргын Тамгын газар	2,701.1	3,088.6	387.5
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	7.8	14.8	7.0
Түнэл Илч ХХК	550.6	534.5	-16.1
Нийт дүн	3,259.5	3,638.0	378.5

Эх сурвалж: Түнэл сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгт 6. Өр төлбөр

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-
Засаг даргын Тамгын газар	0.1	0.0	-0.1
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.0	0.1	0.1
Орон нутгийн хөгжлийн сан	2.4	0.3	-2.1
Түнэл Илч ХХК	23.1	43.8	20.7
Нийт дүн	25.6	44.2	18.6

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, 1 орон нутгийн өмчит компани нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 3 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үе шатны хяналтыг хэрэгжүүлсэн байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 1 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 66.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 66.5 сая төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмжийг өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Түнэл сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Түнэл сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Харьяа байгууллагын зөрчилтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 115.5 сая төгрөгийн 10 зөрчил илэрсэн байна. Аудитаар илэрсэн 4 зөрчилд 12.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 101.5 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

2. Орон нутгийн орлогын биелэлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр авч үзвэл 8 нэр төрлийн 66.5 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрөл бүрээр төлөвлөгөөг биелүүлж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	66.5					1	66.5				
Харьяа байгууллагын зөрчил	1						1					
Дүн	2	66.5					2	66.5				

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № 01/289
танай _____ -ны № _____ -г

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.ЦОГБАЯР
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Түнэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түнэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 186.2 сая төгрөг болж, өмнөх оноос 104.9 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 8 нэр төрлийн орлогын төлөвлөгөө нийт 66.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Түнэл сумын Засаг дарга нь 7 зорилтын 156 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хөвсгөл аймгийн Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг 85.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР